



**БАЙГУУЛЛАГЫН ДАТА ТӨВИЙН ЦАХИЛГААНЫ НӨӨЦ ҮҮСГҮҮР
/ДИЗЕЛЬ ГЕНЕРАТОР/-ИЙН ХУДАЛДАН АВАЛТ, СУУРИЛУУЛАЛТЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Зориулалт: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дата төвийн хэвийн үйл ажиллагааг хангах, гэнэтийн цахилгааны хүчдэл унахад бэлэн байдал хангах.

1. Цахилгаан үүсгүүр /дизель генератор/-ийн ерөнхий шаардлага:

- 1.1.Цахилгаан үүсгүүр нь Caterpillar брэндийн загвар эсхүл түүнтэй дүйцэх Монгол улс болон олон улсын зах зээлд танигдсан байх;
- 1.2.Нийлүүлэгч нь Монгол улсад тухайн цахилгаан үүсгүүрийг борлуулах эрх бүхий албан ёсны гэрээт борлуулагч байх;
- 1.3.Цахилгаан үүсгүүрийг гадаа орчинд суурилуулах тул шаардлага хангасан суурь, цас борооноос хамгаалсан дээвэртэй, хамгаалалтын торон хашаа эсхүл зориулалтын контейнертой байх;
- 1.4.Зориулалтын хамгаалах байгууламжид цахилгаан үүсгүүрийг суурилуулан, автомат сэлгэн залгагчтайгаар цахилгааны холболтыг хийх;
- 1.5.Угсралт суурилуулалт хийхдээ дата төвийн цахилгааны ерөнхий самбар холбох ажлыг гүйцэтгэх;
- 1.6.Нийлүүлэгч тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, хэвийн ажиллагааны талаар сургалт, зааварчилгаа, холбогдох материалуудыг захиалагч талд хүлээлгэн өгөх;
- 1.7.Нэг жилийн засвар, үйлчилгээ үзүүлэх.

2. Суурилуулалт хийх байршил, төрөл:

№	Байршил	Зориулалт
1	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Засгийн газрын XII байрны баруун хойд булангийн хэсэгт.	Гадна

3. Нийлүүлэх барааны тоо хэмжээ:

№	Байршил	Тоо хэмжээ	Зориулалт
1	Гадна суурилуулах цахилгаан үүсгүүр /дизель генератор/	1	Гадна

2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дата төвтэй автомат сэлгэн залгагчтайгаар цахилгаан холболт хийх /дагалдах хэрэгслийн хамт/	1	Гадна/дотор
---	---	---	-------------

4. Цахилгаан үүсгүүр /дизель генератор/-ийн техникийн тодорхойлолт:

Цахилгаан үүсгүүр /дизель генератор/-ийн ерөнхий үзүүлэлт			
1	Хөдөлгүүрийн загвар	1-4 дизель хөдөлгүүр эсвэл үүнтэй дүйцэхүйц	
2	Цилиндрийн хэмжээ	105 мм x 135 мм эсвэл дүйцэхүйц	
3	Цилиндрийн багтаамж	7.0 л эсвэл дүйцэхүйц	
4	Шахалтын харьцаа	16.0:1	
5	Агааржуулалт	Турбо болон агаарын хөргөлттэй	
6	Түлш шахах систем	Шугаман	
7	Удирдлага	Механик	
Хүчин чадлын үзүүлэлт /дүйцэхүйц/			
8	Үндсэн давтамж	50 Гц	
9	Цахилгаан үүсгүүрийн чадлын үнэлгээ	165 кВА	
10	Сэнсний хүчин чадлын коэффициент	132 кВт	
Түлш зарцуулалт /дүйцэхүйц/			
11	Байнгын ажиллагаатай үеийн зарцуулалт	20-25 л/цаг	
12	Ачаалалтай үеийн зарцуулалт	25-30 л/цаг	
13	Түлшний савны багтаамж	400 л –ээс ихгүй байх	
Хөргөлтийн систем /дүйцэхүйц/			
14	Радиаторын агаарын хязгаарлалтын систем	3.0 кДА	
15	Хөргөлтийн шингэний багтаамж	20-30 л	
Генератор /дүйцэхүйц/			
16	Байнгын ажиллагааны горимын хүчдэл	380В/220В	
17	Ачаалалтай ажиллагааны горимын хүчдэл	420В/380В	
18	Хүчдэлийн 30% уналтын үед хөдөлгүүрийн асаах чадвар	<ul style="list-style-type: none"> - Байнгын ажиллагааны үеийн горимд 190/265 кВА - Ачаалалтай ажиллагааны горимд 230 кВА/210 кВА 	
19	Хүчдэлийн 30% уналтын үед хөдөлгүүрийн асаах чадвар	<ul style="list-style-type: none"> - Байнгын ажиллагааны горимд 190кВА/270кВА - Ачаалалтай ажиллагааны горимд 230кВА/220кВА 	
Хэмжээ болон жин /дүйцэхүйц/			
	Урт	Өргөн	Өндөр
20	3500-3600 мм	1100-1140 мм	1740-1760 мм
			Нийт жин
			2100-2300

5. Нэмэлт шаардлага:

5.1. Шалгалт, туршилтыг хийхдээ бүрэн ачаалал авсан үед хийнэ.

5.2. Цахилгаан үүсгүүр /дизель генератор/ нь ISO-9001 стандартын шаардлага хангасан байна.

5.3.Техникийн ашиглалтын заавар, ажиллагааны зарчмын схем, холболтын схемийн зураг дагалдуулна.

5.4.Цахилгаан үүсгүүр /дизель генератор/-ийг DSE зайнаас хандан програм хангамжаар хянах боломжтой байх ба програм хангамжийн тохиргоог хийж хүлээлгэн өгнө.


ХЯНАСАН:

ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД
ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ ИНЖЕНЕР



Ж.ГАЛ

П.НЯМДАВАА

Н.БАТБОЛД